



**ЗАМ, ТЭЭВРИЙН  
ЯАМ**

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН  
ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ  
2025 он

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН  
ТОВЧ ТАЙЛАН**

2026.02.09

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго**

Зам, тээврийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг үндэслэл болгосон.

**Хоёр. Танилцуулга**

Зам, тээврийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайдын тушаалын биелэлт, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт, Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 89.8 хувьтай байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ерөнхий дүнг Хүснэгт №1-д харуулав.

*Хүснэгт №1*

№	Хяналтад байх арга хэмжээ	2025 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь	Жин
1.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	-	-	-
2.	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	-	-	-
3.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	49	92.2	20
4.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	15	90.0	20
5.	Сайдын тушаалын хэрэгжилт	110	83.5	10
6.	Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт	96	94.8	10

7.	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	3	88.7	10
8.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	-	-	-
9.	Зам, тээврийн сайдын аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээ, "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт	-	-	-
10.	Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	-	-	-
<b>Нийт</b>			<b>89.8</b>	<b>90.2</b>

### 2.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд харуулав.

*Хүснэгт №2*

Нийт заалт	Үүнээс:						Хугацаа болоогүй	Биелэлт (хувиар)
	100 хувь	90 хувь	70 хувь	50 хувь	30 хувь	0 хувь		
<b>49</b>	<b>41</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>92.2</b>

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 2025 онд 49 арга хэмжээ хэрэгжүүлэхээр Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлан ажилласан байна. Жилийн эцсийн байдлаар нийт 49 арга хэмжээнээс 100 хувийн биелэлттэй 41 арга хэмжээ, 90 хувийн биелэлттэй 2 арга хэмжээ, 70 хувийн биелэлттэй 3 арга хэмжээ, 30 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ, хэрэгжээгүй 2 арга хэмжээ байгаа бөгөөд хэрэгжилтийн дундаж 92.2 хувьтай байна.

### Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

*Хүснэгт №3*

№	Арга хэмжээний заалт, агуулга	Зорилтот түвшин	Хугацаа	Биелэлт	Хувь
1.	4.1.1.1. "Автоматээр ийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2022-2025 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаа	IV улирал: Төлөвлөгөөний дагуу санхүүгийн хяналт шалгалтыг хийж хэрэгжилтийг 90 хувьд хүргэнэ.	I-IV улирал	2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан 12/02 удирдамжийн дагуу "АТҮТ" ТӨҮГ-ын төсөв санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж байна.	30
2.	1.5.1. Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	III улирал: Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтэд 2025 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2025 оны 8 дугаар	III улирал	Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын биелэлтийг аваагүй буюу <a href="http://www.unelgee.gov.mn">www.unelgee.gov.mn</a>	0

		сарын 01-ний өдрийн дотор ЭЗХЯ-нд хүргүүлж, <a href="http://www.unelgee.gov.mn">www.unelgee.gov.mn</a> сайтуудад байршуулсан байна. Ажлын явцыг сайжруулах талаар зөвлөмжийг холбогдох газар, хэлтсүүдэд хүргүүлнэ.		сайтад байршуулаагүй байна.	
3.	4.1.1.2. "Ховд АЗЗА" ТӨХК-ийн 2020-2025 оны санхүүгийн үйл ажиллагаа	IV улирал: Төлөвлөгөөний дагуу санхүүгийн хяналт шалгалтыг хийж хэрэгжилтийг 90 хувьд хүргэнэ.	I-IV улирал	Зам, тээврийн яамны Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд 2024 онд хийсэн хяналт шалгалтаар "Ховд АЗЗА" ТӨХК-тай холбоотой асуудлыг шалгуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн тул 2025 онд тус компанид хяналт шалгалт хийх шаардлагагүй болсон.	0

**2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэвэл:**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр тус газарт 15 үүрэг даалгавар өгөгдсөнөөс бүрэн хэрэгжсэн 12, хэрэгжих шатанд 3 арга хэмжээ байгаа бөгөөд дундаж үнэлгээ нь 90.0 хувь байна.

*Хүснэгт №4*

Нийт заалт	Үүнээс:					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэг жээгүй	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
15	12	3	-	-	-	90.0

**2.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:**

Сайдын тушаалаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт өгөгдсөн 110 үүрэг даалгавраас бүрэн хэрэгжсэн 80, хэрэгжих шатанд 12, хэрэгжээгүй 11, хэрэгжилт тооцох хугацаа болоогүй 4, хүчингүй болсон 3 үүрэг даалгавар байна. Харин тус газарт хамаарах 4 үүрэг даалгавар нь бүрэн хэрэгжсэн байна. Хүснэгт №5-д харуулав.

*Хүснэгт №5*

Нийт заалт	Үүнээс:					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэг жээгүй	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
110	80	12	11	4	3	83.5

**2.4. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:**

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт өгөгдсөн 96 үүрэг даалгавраас "тушаалын хэрэгжилтэд хяналт

тавьж ажиллах тухай” 86 үүрэг даалгавар байна. Харин тус газарт хамаарах 11 үүрэг даалгавраас 1 үүрэг, даалгавар хэрэгжих шатанд, 10 үүрэг, даалгавар бүрэн хэрэгжсэн байна. Үнэлгээг Хүснэгт №6-д харуулав.

*Хүснэгт №6*

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэг жээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
96	88	6	2	-	-	94.8

### 2.5. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээ:

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд тус газраас 2025 онд Зам, тээврийн яам түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагаа, гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ, санхүүгийн хяналт шалгалт хийсэн ажлын тайлан зэрэг 17 мэдээллийг яамны сайтад шинээр байршуулж, ил тод, нээлттэй мэдээлж ажилласан. Үнэлгээг Хүснэгт №7-д харуулав.

*Хүснэгт №7*

д/д	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн оноо				Үнэлгээ (хувь)
		МХБ	ХНБ	МБББ	ЭСТБ	
1.	Үйл ажиллагааны тайлан, Мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ	30	30	30	10	83
2.	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	30	30	30	10	83
3.	Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж	30	30	30	30	100
<b>Дүн</b>						<b>88.7</b>

### Гурав. Үнэлэлт, дүгнэлт

#### 3.1. Төлөвлөлтийн байдал:

3.1.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын үйл ажиллагааны онцлог нь тогтмол байнгын давтагдах шинжтэй байдаг. 2025 онд тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 49 арга хэмжээг төлөвлөсөн байна. Үүнээс хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр 18 арга хэмжээ, санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр 16, дотоод аудитын чиглэлээр 13, хяналт-шинжилгээ, үнэлгээний журам шинэчлэн боловсруулах, хяналт-шинжилгээ, үнэлгээний программыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэлээр 2 арга хэмжээг төлөвлөгөөнд тусгасан байна.

#### 3.2. Хэрэгжилтийн байдал:

3.2.1. Зам, тээврийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 оны жилийн эцсийн үйл ажиллагааг Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын биелэлт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээ гэсэн 5 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 89.8 хувиар үнэлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.2 хувийн өсөлттэй байна.

3.2.2. Газрын төлөвлөгөөнд туссан хэрэгжээгүй арга хэмжээ болох "Ховд АЗЗА" ТӨХК-ийн 2020-2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийхээр тусгасан ч Зам, тээврийн яамны Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд 2024 онд хийсэн хяналт шалгалтаар "Ховд АЗЗА" ТӨХК-тай холбоотой асуудлыг шалгуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн тул 2025 онд тус компанид хяналт шалгалт хийх шаардлагагүй болсон байна.

3.2.3. "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2022-2025 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаанд хийх санхүүгийн хяналт шалгалт, Яамны өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хэрэгжилтэд дотоод аудит хийхээр төлөвлөсөн арга хэмжээний удирдамжийг тайлант оны 12 дугаар сард баталсан тул уг шалгалтуудыг он дамнуулан хийж гүйцэтгэсэн байна.

3.2.4. Газрын төлөвлөгөөний 3 дугаар зорилтын хүрээнд Хяналт-шинжилгээ, үнэлгээний программыг шинэчлэн, яамны үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр төлөвлөсөн ч бүрэн хэрэгжээгүй тул 2026 оны яам болон газрын төлөвлөгөөнд дахин тусгасан байна.

3.2.5. Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт:

Тайлант хугацаанд тус газарт ЗГХХГ-аас Зам, тээврийн яамны 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 18 хувьтай байна.

3.2.6. Тус газраас 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 49 арга хэмжээний хэрэгжилт 92.2 хувьтай байна. Үүнээс 87.8 хувь нь хангалттай буюу бүрэн хангалттай, 12.2 хувь нь төлөвлөсөн үр дүндээ бүрэн хүрээгүй байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь Хүснэгт №8-д харуулав.

*Хүснэгт №8*

Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
Зорилт 1. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулна.	7	85.7
Зорилт 2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	6	100
Зорилт 3. Яам, харьяа байгууллагуудын 2025 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	7	95.7
Зорилт 4. Зам, тээврийн салбарын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж, зөрчил, дутагдлыг бууруулах арга хэмжээ авна.	16	87.5
Зорилт 5. Зам, тээврийн салбарын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.	13	96.1

### **3.3. Өмнөх Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн байдал:**

3.3.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хяналт-шинжилгээ,

үнэлгээ хариуцсан ажлын байрны сул орон тоог яаралтай нөхөх, ажлын ачаалал болон ажил үүргийн тэнцвэртэй байдлыг хангах чиглэлээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.

3.3.2. Газрын 2025 гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан дотоод аудитын төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 92.8 хувьтай хэрэгжсэн байна.

3.3.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний программын хэвийн ажиллагааг хангуулах зөвлөмж өгсөн боловч тайлант хугацаанд хэрэгжилт бүрэн хангагдаагүй тул 2026 оны газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дахин тусгаж хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авсан байна.

3.3.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журмыг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмжийн хүрээнд Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, хийж, үнэлж дүгнэх журам”-ыг батлуулж, 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

#### **Дөрөв. Санал, зөвлөмж**

4.1. Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, хийж, үнэлж дүгнэх журам”-ын 2.13-т зааснаар Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт, шалгалт, аудитын хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланд тусгах, тайланг хүлээн авах, нэгтгэх хугацааг тодорхой болгон журамд нэмэлт өөрчлөлт оруулах;

4.2. Газрын төлөвлөгөөнд туссан арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж ажиллахад анхаарахыг албан хаагчдад зөвлөж байна.

СХШҮДАГ